



“БУЛИГААР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 04-р сарын 21-ний өдөр

Дугаар 23-01

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн 14:00 цагт ХУД-ийн 2-р хороо Арьс ширний үйлдвэрийн хашаанд байрлах өөрийн байранд зохион байгуулагдав. Хурлыг Булигаар ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Анхболд даргалж, Хувьцаа эзэмшигчид, ТУЗ-ийн хараат бус гишүүд нар оролцов.

ТУЗ-ийн хараат бус гишүүн Т.Болд: ТУЗ-ийн дарга А.Энхмэнд хүндэтгэх шалтгаанаар хуралд биечлэн оролцох боломжгүй болсон тул Б.Анхболд гишүүн хурлыг даргаар шийдвэрлэсэн байгаа

Хурлын дарга Б.Анхболд: Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая. Булигаар ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал эхлэхэд бэлэн боллоо. Хурлаа албан ёсоор эхлүүлэхээс өмнө хурлыг албажуулах ёстой бөгөөд Тооллогын комиссоос хурлын ирцийн мэдээллийг өгнө үү хэмээн хүсэж байна.

ХУРЛЫН ИРЦИЙГ ТАНИЛЦУУЛАХ:

Тооллогын комиссын дарга Ю.Дүгэрмаа: Булигаар ХК-ийн 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийг мэдээлье. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны 03 дүгээр сарын 31-ний өдрөөр тогтоосныг дурдъя. Бүртгэлийн өдрөөр Булигаар ХК-ийн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны тоо 400,212,000 ширхэг байснаас хурлын материалтай урьдчилан танилцан санал өгөх хэлбэрээр 156,630,000 саналын эрхтэй 1 хувьцаа эзэмшигч, өнөөдрийн хурал биечлэн оролцох арга хэлбэрээр 352,815,764 ширхэг саналын эрхтэй 10 хувьцаа эзэмшигч оролцсоноор нийт ирц **88.16** хувь хувь болсноор Компанийн тухай хуулийн 69.1-д заасны дагуу хурлын ирц бүрдсэнийг мэдэгдэж байна.

ХУРЛЫН ДЭГИЙГ ТАНИЛЦУУЛАХ:

Хурлын дарга Б.Анхболд: Тооллогын комисстоо баярлалаа. Хурлын дэгийг товч танилцуулахад:

- Тооллогын комисс томилсон тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулна.
- Хэлэлцэх асуудлын дагуу илтгэлүүдийг та бүхэнд хүргэнэ.
- Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой асуултад хариулт явагдана.
- Санал хураалт явагдана.
- Тооллогын комисс санал хураалтын дүнг нэгтгээд үр дүнгээ танилцуулна.
- Хурлаас гарах шийдвэрүүдийг тогтоол болгож та бүхэнд танилцуулаад хурал албан ёсоор дуусах юм.

Хурлаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя. Бид энэхүү хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэж, 3-н асуудал дээр санал авч шийдвэр гаргах байгаа.

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах
2. Компанийн 2023 оны бизнес төлөвлөгөөг танилцуулах

3. Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах
4. Компанийн 2022 оны санхүүгийн тайлан, түүнд хийсэн хараат бус аудитын дүгнэлтийг танилцуулах
5. 2021 оны ногдол ашиг тараалтын тухай болон 2022 онд ногдол ашиг тараах тухай ТУЗ-ийн гаргасан тогтоолыг танилцуулна.
6. ТУЗ-ийн үйл ажиллагааны товч тайланг танилцуулах
7. ТУЗ-ийн үйл ажиллагааны зардлын төсөв танилцуулж, батлах тухай хэлэлцэн санал авна.
8. Компанийн ТУЗ-ийн гишүүдийг сонгох талаар мэдээллийг та бүхэнд хүргэж санал хураалтаар шийдвэр гарна.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛУУДЫГ ТАНИЛЦУУЛАХ:

Нэг. Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах.

Гүйцэтгэх захирал Б.Анхболд: Булигаар ХК нь 2022 онд 9.0 тэрбум төгрөгийн борлуулалтын төлөвлөгөөтэй ажилласан бол бодит гүйцэтгэлээр 8 тэрбум 537 сая төгрөгийн борлуулалт хийж, борлуулалтын төлөвлөгөө 94.8 хувийн биелэлтэй ажиллаж, өмнөх оноос 38 хувиар өсгөж чадсан. Үүнээс 429.5 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь өмнөх оноос 11 хувийн өсөлттэй байна.

2021 оноос эхлэн гадаад зах зээл рүү борлуулалт хийж эхэлснээр ба тухай онд нийт борлуулалтын 8.6%-ийг эзэлж байсан бол 2022 онд нийт борлуулалтын 21%-ийг гадаад борлуулалт бүрдүүлэх болсон. Гадаад борлуулалтын төлөвлөгөөний биелэлтийг 91.1 хувь, дотоод борлуулалтын төлөвлөгөөний биелэлт 96.7 хувьд хүрчээ.

2022 оны төлөвлөгөөнд бид үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх тал дээр түлхүү анхаарч ажилласан. 2021 онд 548 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн бол 2022 онд 1.3 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 1.6 тэрбум болж өссөн. Үүнд нөлөөлсөн хүчин зүйлс нь төгрөгийн ханш сулрах болон үнийн өсөлттэй холбоотой. Хөрөнгө оруулалтын 76.6 хувийг үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмж, 22.7 хувийг төгрөгийг барилга байгууламжийн бүтээн байгуулалт, 0.7% хувийг бусад хөрөнгө оруулалтад зарцуулсан байна.

Хамгийн гол хөрөнгө оруулалт нь 210,000 еврогийн үнэтэй хуваах машин эзэлж байна. Италийн улсын Mosconi брэндийн уг машин нь өдөрт 1500 бодийн арьс хуваах хүчин чадалтай элэгдэл багатай гэдгээрээ давуу талтай. Итали улсын Mosconi компани нь 1946 оноос арьс шир боловсруулах машин үйлдвэрлэж эхэлсэн. Тэр цагаас хойш тус компани нь технологийн тасралтгүй хувьсал, шинэ шийдлүүдийг олохын тулд судалгаа, хөгжилд байнга хөрөнгө оруулалт хийснээр арьс шир боловсруулах зориулалттай хамгийн сүүлийн үеийн машин үйлдвэрлэх болсон.

Дараагийн хөрөнгө оруулалт бол БНХАУ-аас 191,266,952 төгрөгөөр махлах машин худалдаж авсан. Мөн будгийн шүрших машиныг 96,505,968 төгрөгөөр шинэчилсэн. Ингэснээр бид 1 арьсанд зарцуулах будгийн хэмжээ 30 хувиар багассан. 31,669,899 төгрөгөөр агаарын гинжин хатаалга хийснээр арьсыг удаан хатааж уян зөөлөн болгох, арьсны чанарт сайнаар нөлөөлж байгаа. Хромын барабаныг 24,974,602 төгрөгөөр тоноглол хийж будгийн барабан болгон шинэчилснээр нэг удаадаа 500 арьс будах боломжтой болсон. Үндсэндээ эдгээр гол үндсэн 5 хөрөнгө оруулалт хийсэн байна.

Компанийн боловсруулан үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнийг олон нийтэд сурталчлах дотоодын арьс ширэн бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч нарыг өөрсдийн үйлдвэрлэсэн арьс ширээр хангах зорилготойгоор арьс ширэн бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч нарт зориулж Булигаар ХК жил бүр leather partners 2022 арга хэмжээг 4 дэх жилдээ амжилттай зохион байгуулсан бөгөөд энэ жил 100 гаруй аж ахуйн нэгж оролцсон.

Үйлдвэрийн дэргэд Шинээр баригдсан цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажлыг 2021 оноос эхлэн барьж эхэлсэн бөгөөд 2022 оны 6 дугаар сард ашиглалтад оруулсан. Уг цэвэрлэх байгууламжийн хүчин чадал нь хоногт 150 м3 үйлдвэрийн хаягдал усыг Монгол Улсын MNS:4943-2015 стандартын түвшинд хүргэж цэвэршүүлэх, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах зорилготой. Цэвэрлэх байгууламж нь бохир усыг физик болон химийн аргаар цэвэрлэх, лаг усгүйжүүлэх гэсэн үндсэн хоёр технологийн дагуу ажиллана.

Өнөөдрийн байдлаар компанид 80 гаруй ажилтнуудтай бөгөөд захиргаа, үйлчилгээнд 19, үйлдвэрийн цехэд 61 ажиллаж байна. н ажиллаж байна. Нийт ажилтнуудын 63% орчим нь 40 хүртэлх насны залуучууд эзэлж байна. Хэдийгээр боловсруулах үйлдвэр боловч ажилтнуудын хүйсийн харьцаа эрэгтэй 57 хувь, эмэгтэй 43 хувийг эзэлж байгаа нь хүйсийн тэнцвэртэй байдалтай байна. 2022 оны 10-р сард нийт ажилтнуудын цалин хөлс 20 хувиар нэмэгдсэн.

Ажилтнуудын дундаж цалинг 20% буюу үндсэн цалинг дунджаар 200,000 төгрөгөөр өссөн байгаа нь энэ цаг үед хамгийн сайн үзүүлэлт гэж дүгнэж байна. Мөн цалингийн өсөлт болон бусад хүчин зүйлсээс болоод бүтээгдэхүүний үнэ нэмэгдсэн байгаа. Гэхдээ бид цаашдаа барьж ажиллахаар төлөвлөж байгаа. Ажлын байранд цомхотгол хийгдээгүй бөгөөд нийгмийн хариуцлагын хүрээнд 2 хөгжлийн бэрхшээлтэй ажилчид ажиллуулж байгаа. Бид мөн технологичдын мэдлэг чадварыг хөгжүүлэх гаднын байгууллагуудад туршлага судлуулах ажлуудыг мөн хийж гүйцэтгэсэн. Нийт ажилтнуудын эрүүл мэндийг тандах, ердийн болон мэргэжлээс шалтгаалсан өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг эрт үед илрүүлж, эмчлэн эрүүлжүүлэх зорилгоор компанийн ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт жил тутам хамруулдаг.

2022 онд СБД-ийн Эрүүл мэндийн төвтэй хамтран 70 гаруй ажилтнуудыг үзлэг шинжилгээнд хамруулсан.

Компанийн нийт ажилтнуудын оролцоотойгоор компанийн ойр орчимд 500 гаруй хайлаас мод тарьж, 260 гаруй м.кв-ыг зүлэгжүүлэн ногоо байгууламжийг бүрдүүлэв.

Заа 2022 оны хувьд товчхондоо танилцуулахад ийм байна.

Хоёр. Компанийн 2023 оны бизнес төлөвлөгөөг танилцуулах

2023 онд хийгдэхээр төлөвлөж буй хөрөнгө оруулалтын хувьд 1.5 тэрбум төгрөг зарцуулахаар төсөвлөснөөс 2023 онд үйлдвэрт зайлшгүй шаардлагатай нийт 5 төрлийн тоног төхөөрөмж худалдан авах, сэлбэг солих, засвар үйлчилгээ хийх шаардлагатай байгаа ба нийт 1.001,582,306 төгрөг 2023 оны 1-р сард авсан үнийн санал дээр тулгуурлаж гаргав. Үүнд:

Шахах машин	1 ширхэг, шинэ	₮ 280,622,337
Погрушик	1 ширхэг, шинэ	₮105,233,376
Индүү машин	1 ширхэг, шинэ	₮ 422,798,736
Агаарын хатаалга	1 ширхэг, сэлбэг	₮ 35,077,792
Шүрших машин	1 ширхэг,сэлбэг	₮157,850,065

2019 оноос хойш тасралтгүй барилга байгууламжийн засвар хийсээр байгаа ба энэ онд үйлдвэрийн гадна тохижилт, Үйлдвэрийн Байрны нийт 8564кв.м талбайн засвар хийхээр төлөвлөж, 500 сая төгрөгийг төсөвлөв.

Үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр бид түүхий эдэд 60,000 үхрийн ширийг 2023 оны 1 сарын байдлаар нэгж үнэ 25,000 төгрөгт, нийт 1.5 тэрбум төгрөгөөр худалдан авч, гүн боловсруулах ба түүнд зарцуулагдах химийн материалын зардал 2.4 тэрбум гаруй төгрөг гарахаар байна.

Булигаар ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу төсөвлөсөн нийт зардлын дүн урьдчилсан байдлаар 11 тэрбум 569 сая төгрөг зарцуулагдахаар тооцоолсноос үндсэн хөрөнгөд 1 тэрбум 594 сая, зээл болон зээлийн хүүгийн төлбөрт 2 тэрбум 212 сая, үйл ажиллагааны зардалд 7 тэрбум 762 сая төгрөг зарцуулна гэж тооцоолсон.

Бид 2023 онд 11 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олохоор орлогын таамаглалтай ажиллаж байгаа бөгөөд нийт 60,000 үхрийн ширийг гүн боловсруулж, бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн эрэлтэд голлох 3 төрлийн артикл буюу хэв шинжтэйгээр үйлдвэрлэн худалдаалахаар төлөвлөж байна. Үүнд үхрийн хром, болигаар, ажлын гутлын артай хром нэр төрөл орно. Үхрийн ширний борлуулалтын орлого нийт 7.2 тэрбум төгрөг гэж урьдчилан төлөвлөж байна.

Ямааны арьс нь гутлын дотор хийгдэх гол үндсэн түүхий эд болдог ба бид ямааны вет-блю болон краст арьсыг гадагшаа экспортод гаргадаг. 2023 онд урьдчилсан тооцооллоор ямааны краст 100,000 ширхэг, нэгжийн үнэ \$3, ямааны вет-блю 180,000 ширхэг нэгжийн үнэ \$1.8-р экспортолж, нийт 2.6 тэрбум төгрөгийн борлуулалтын орлогыг тус тус бүрдүүлэхээр ажиллаж байна.

Хувьцаа эзэмшигч Д.Энхтуяа: Аль улс руу экспортлож байгаа вэ? Мөн краст арьс 1ш-ийн үнэ нь 3 доллар, ямааны арьс 1ш 1.8 доллар гэж байна. Яагаад ийм бага үнээр гарч байгаа вэ? боловсруулахад үйлдвэрлэлийн зардал их орж байгаа шүү дээ.

Гүйцэтгэх захирал Б.Анхболд: Ямааны арьсыг БНТУ- руу ихэвчлэн гаргаж байгаа. Өөр улс руу ямааны арьс бол ихээр гарахгүй байгаа. Одоо Турк улсад Монгол улсаас авсан арьсаараа зөвхөн дотрын арьсны зориулалтаар авдаг. Хятад улс руу энэ үнээр гаргах гэвэл авахгүй. Илүү хямдаар зарах болно. Ихэвчлэн гахай арьсаар дотор хийдэг.

Хувьцаа эзэмшигч Д.Энхтуяа: Одоо энэ үнэд тээврийн зардал орсон үнэ үү?

Гүйцэтгэх захирал Б.Анхболд: Үгүй ээ. Тээврийн зардал ороод 2.5 доллар болдог. Бид Европоос ачаа ачиж Монгол руу орж ирсэн машинд буцахад нь тавьж явуулдаг. Бас арьсны борлуулалт муудахад нөлөөлж байгаа гол зүйлс нь загварын чиг хандлага нөлөөлж байна. Химийн шинжлэх ухааны тусламжтайгаар хямд хиймэл арьс гаргаж аваад жил бүр загварын чиг хандлагыг өөрчилж байна.

Хувьцаа эзэмшигч Ж.Энхтунгалаг: Одоо энэ хуваах машин үхрийн арьсийг хэдэн давхрага болгож хувааж байгаа вэ?

Гүйцэтгэх захирал Б.Анхболд: Хэд бол хэд л хуваах боломжтой. Гэхдээ тийм олон 7-8 хувааж байгаа улсын одоогоор мэдэхгүй юм. Миний харж мэдснээр Хятад улсад 3 хувааж байсан. Бид одоогоор 2 хувааж байгаа. Урьд нь хуваах машин байхгүй үед бид хусахаар арьсаа нимгэлдэг байсан. Энэ эдийн засгийн төдийгүй бүтээмжийн хувьд ихээхэн сөрөг үр дагавартай байсан. Хуваах машинтай болсноор хүссэн зузааны хэмжээгээр арьсаа хувааж байгаа нь химийн бодис ашиглалтад ихээхэн хэмнэлт хийж байгаа. Ажлын бүтээмжийн хувьд ч гэсэн.

Заа анхаарал тавьсанд баярлалаа.

**Гурав. Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлан болон
санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг
хэлэлцэн батлах**

Булигаар ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх дүгнэлтийг Компанийн тухай хууль, Булигаар ХК-ийн дүрмийн холбогдох заалтын

дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж байна.

Булигаар ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь тус компанийн 2022 оны бизнес төлөвлөгөөг баталж, Компанийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжуудыг мөрдлөг болгон компанийг удирдах үйл ажиллагаандаа засаглалын зарчмууд, компанийн дүрмийг мөрдлөг болгож компанийн үйл ажиллагаа, томоохон гэрээ хэлэлцээр, жилийн тайлан, мэдээлэлтэй танилцаж холбогдох шийдвэр, зөвлөмж, үүрэг даалгавруудыг өгч, биелэлтэд хяналт тавьж ажиллалаа. Компанийн гүйцэтгэх удирдлагын баг нь Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр зөвлөмж, төлөвлөгөөт зорилтыг амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна.

Булигаар ХК нь 2022 онд 9.0 тэрбум төгрөгийн борлуулалтын төлөвлөгөөтэй ажилласан бол бодит гүйцэтгэлээр 8,537.6 сая төгрөгийн борлуулалт хийж, борлуулалтын төлөвлөгөө 94.8 хувийн биелэлтэй ажиллаж, өмнөх оноос 38.1 хувиар өсгөж чадсан ба 2022 оны зорилтот түвшингийн биелэлт 94.8 хувь буюу 429.5 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан.

Гадаад борлуулалтын төлөвлөгөөний биелэлтийг 91.1 хувь, дотоод борлуулалтын төлөвлөгөөний биелэлт 96.7 хувьд хүрчээ.

2022 онд нийт 1,682.65 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсний 76.6 хувийг үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмж, 22.7 хувийг төгрөгийг барилга байгууламжийн бүтээн байгуулалт, 0.7% хувийг бусад хөрөнгө оруулалтад зарцуулсан байна.

Тус компани өнгөрсөн онд нийтдээ 6,179,386,557.39 төгрөгийн орлого олсон. Тайлант хугацаанд өнгөрсөн оныхоос 2,358,266,974.95 төгрөгөөр борлуулалт нэмэгдсэн байна. Тайлант хугацаанд 1,536,784,517.87 төгрөгийн үйл ажиллагааны зардал гарсан бөгөөд өмнөх онтой харьцуулахад 150,416,670.47 төгрөгөөр буурсан бөгөөд үүнээс үйл ажиллагааны зардлын 684,476,741 төгрөгийг ашиглалтад, 41,647,839.65 төгрөгийг урсгал засвар хийхэд, 368,528,878 төгрөгийг зээлийн хүүгийн зардалд зарцуулсан байна.

Тайлант үеийн жилийн эцсийн байдлаар нийт хөрөнгийн дүн 32,361,808,194.27 төгрөг, үүнээс эргэлтийн хөрөнгө 40.13 хувь буюу 12,989,285,959.81 төгрөг, эргэлтийн бус хөрөнгө 59.86 хувь буюу 19,372,522,234.46 төгрөгийг эзэлж байна.

Эргэлтийн хөрөнгийн 0.19 хувь буюу 24,992,984.77 төгрөгийг мөнгө, авлага зэрэг түргэн хөрвөх хөрөнгө 57.6 хувь буюу 7,483,238,441.50 төгрөг, бараа материалд 34.5 хувь буюу 4,490,572,645.40 төгрөг, урьдчилж төлөгдсөн зардалд 7.6 хувь 990,481,995.58 эзэлж байна. Эргэлтийн бус хөрөнгийн дийлэнх хувь болох 97.92 хувь буюу 18,969,629,085.71 төгрөгийг үндсэн хөрөнгө болох барилга байгууламж, машин тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил, 2.08 хувь буюу 402,893,148.75 төгрөгийг биет бус хөрөнгө эзэлж байна.

Өр төлбөр ба Эзэмшигчдийн өмчийн хувьд бусдад төлөх өр төлбөрийн хэмжээ 20,634,263,291.41 төгрөг, эзэмшигчдийн өмчийн дүн 11,727,544,902.86 төгрөг байна. Нийт өр төлбөрийн 23.73 хувь буюу 4,896,436,539.65 төгрөгийг богино хугацаат өр төлбөр, 76.27 хувь буюу 15,737,826,751.76 төгрөгийг урт хугацаат өр төлбөр эзэлж байна. Эзэмшигчдийн өмч оны эхэнд 4,466,386,668.24 төгрөг байсан бол оны эцэст 11,727,544,902.86 төгрөг болж нь хуримтлагдсан алдагдал өссөнтэй холбоотой байна.

Түүнчлэн “Булигаар ХК-ийн 2022 оны жилийн санхүүгийн тайлан”-д санхүүгийн аудитын тайланг “Сэрэлт дөл аудит” ХХК-иар хийж гүйцэтгүүлсэн бөгөөд уг санхүүгийн аудитын дүгнэлтийн дагуу санхүүгийн тайлан хангалттай гэж дүгнэгдсэн.

Гүйцэтгэх удирдлагын баг 2022 онд төлөвлөсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн ашиглаж, компанийн үр ашгийг нэмэгдүүлэх, хэтийн зорилгодоо хүрэх, компанийн хөгжлийг урагшлуулах үр дүнтэй алхмуудыг хийж, Монгол Улсын хуулийн хүрээнд зах зээлийн өнөөгийн байдалд зохицсон үйл ажиллагааг явуулж ажилласан байна.

Иймд “Булигаар” хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс 2022 оны компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайланд “Хангалттай” гэсэн дүгнэлт өгч байна.

**Дөрөв. Компанийн 2022 оны санхүүгийн тайлан, түүнд
хийсэн хараат бус аудитын дүгнэлтийг танилцуулах**

Хөндлөнгийн аудит: “Булигаар ХК-ийн 2022 оны жилийн санхүүгийн тайлан”-д санхүүгийн аудитын тайланг “Сэрэлт дөл аудит” ХХК нь хийж гүйцэтгэсэн бөгөөд уг санхүүгийн аудитын дүгнэлтээр 2022 оны 12 дугар сарын 31-ны өдрийн байдлаарх санхүүгийн байдал, уг өдрийн тасалбар болгосон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт-д нийцүүлэн Монгол Улсын сангийн яам, СЗХ-оос гаргасан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна гэж дүгнэгдсэн.

Аудитын дэлгэрэнгүйг дүгнэлтийг тарааж өгсөн материалаас танилцах боломжтой байгаа.

**Тав. 2021 оны ногдол ашиг тараалтын тухай болон 2022
онд ногдол ашиг тараах тухай ТУЗ-ийн гаргасан
тогтоолыг танилцуулах**

ТУЗ-ийн гишүүн Ц.Мөнхлхагва: 2021 оны ногдол ашиг тараалтын тухай: Компанийн ТУЗ-ийн 2022 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 02 тоот тогтоолоо нэгж хувьцаанд 600 төгрөг хуваарилахаар шийдвэр гаргасан. Ногдол ашгийг 2022 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тасалбар болгож 2022 оны 07 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв”-өөр дамжуулан олгохоор ногдол ашиг зуучлуулан тараах гэрээний дагуу нийт 687 хувьцаа эзэмшигчийн дансанд 47,586 ширхэг хувьцаанд ногдох 26,739,030 төгрөгийг байршуулсан. 5-аас дээш хувь эзэмшдэг хувьцаа эзэмшигчийн хүсэлтийн дагуу компаниас 3 хувьцаа эзэмшигчид ногдол ашигт ногдох мөнгийг олгосон. Нийт ногдол ашигт: 690 хувьцаа эзэмшигчд 240,127,200 төгрөгийн бүрэн олгосон.

Булигаар ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023.02.15-ны өдрийн 03/23 тоот тогтоолоор: “Булигаар” ХК-ийн 2022 оны жилийн эцсийн цэвэр ашгаас компанийн Хувьцаа эзэмшигчдэд олгох нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийг 0.25 (тэг зууны хорин таван) төгрөгөөр тогтоосон бөгөөд

Ногдол ашиг авах эрхтэй компанийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоон, 2023.09.01-ний өдрөөс эхлэн олгохоор шийдвэрлэсэн.

Ногдол ашиг тараах тухай ТУЗ-ийн тогтоолыг тарааж өгсөн материалаас танилцах боломжтой байгаа.

**Зургаа. ТУЗ-ийн үйл ажиллагааны товч тайланг
танилцуулах**

ТУЗ-ийн хараат бус гишүүн Ж.Эрдэнэбат: Төлөөлөн удирдах зөвлөл нь сонгуульт хугацаандаа 80-100 хувийн ирцтэйгээр 7 удаагийн хуралдаанаар 22 тогтоол, 7 тэмдэглэлээр шийдвэр гарган, хэрэгжилтэд хяналт тавин ажилласан байна. ТУЗ-ийн хурлыг танхимаар, цахимаар, эчнээгээр зохион байгууллаа.

“Санхүүгийн зохицуулах хороо”-ны 2022 оны 03 сарын 23-ны өдрийн №145 тоот тогтоолоор “Компанийн засаглалын кодекс” шинэчлэгдэн батлагдсаны дагуу “Булигаар” ХК-ийн ТУЗ-ийн 2022.05.06-ны өдрийн №11/22 тоот тогтоолоор

Компанийн засаглалын кодексыг хэрэгжүүлэх хөтөлбөрийг баталсан. Тус хөтөлбөрийн хүрээнд үе шаттайгаар компанийн засаглалын бодлого, дүрэм журмуудыг кодекст нийцүүлэх ажлыг хийхээр төлөвлөсөн. Үүний хүрээнд “Булигаар” ХК-ийн ТУЗ-аас дараах журам болон баримт бичгүүдийг баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.

ТУЗ-ийн 2022 оны 5-р сарын 04-ний өдрийн 08/22 тоот тогтоолоор ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг баталсан.

ТУЗ-ийн 2022 оны 10-р сарын 14-ний өдрийн 20/22, 21/22 тоот тогтоолоор ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааны журмуудыг баталсан. Үүнд:

1. Аудитын хорооны үйл ажиллагааны журам
2. Цалин урамшууллын хорооны үйл ажиллагааны журам
3. Нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааны журам
4. Ногдол ашгийн бодлого
5. Залгамж халааны бодлого
6. Цалин, урамшууллын бодлого
7. Комплайнсын хяналтын бодлого
8. Дотоод хяналтын бодлого
9. Дотоод аудитын бодлого
10. Эрсдэлийн удирдлагын бодлого

ТУЗ-ийн 2022 оны 12-р сарын 16-ны өдрийн 23/22, 24/22 тоот тогтоолуудаар дараах журмуудыг баталсан. Үүнд:

1. Ёс зүйн дүрэм
2. Шүгэл үлээх журам
3. Мэдээлэл хүргэх журам
4. ТУЗ-ийн гишүүдэд танилцуулга хийх

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны зардлын хувьд тайлант хугацаанд 108,836,600 төгрөгийн зардал (2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 02/22 тоот тогтоолоор батлагдсан.) төлөвлөж, гүйцэтгэл 66,681,850 төгрөг буюу 61.2 хувийн зарцуулалттай байна. Зардлын 80 орчим хувь нь хувьцаа хуваах болох гарахтай холбоотой үйлчилгээний төлбөр орсон байгаа. Мөн 2022 онд хувьцаа эзэмшигчдийн хурал 2 удаа хуралдсан байгаа.

Долоо. ТУЗ-ийн үйл ажиллагааны зардлын төсөв танилцуулж, батлах

ТУЗ-ийн хараат бус гишүүн Ж.Эрдэнэбат: ТУЗ-ийн үйл ажиллагааны зардлын төсвийг танилцуулъя. ТУЗ-ийн хараат бус гишүүний цалин жилд 6 давтамжтайгаар 250,000 төгрөгийг олгохоор нийтдээ жилд 4,5 сая төгрөг, Бичиг хэрэг, хурлын зардалд 9,096,700 төгрөгийг төсөвлөсөн байна. Бусад зардлын хувьд МХБ болон ҮЦТХТ-ийн үйлчилгээний хураамж, бичиг хэрэг, цай кофе, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зардал багтсан байгаа.

Найм. Компанийн ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга.

Төлөөлөн удирдах зөвлөл: ТУЗ-ийн хараат болон ердийн гишүүдээ энэ чиглэлийн салбартаа тэргүүлэгч мэргэжилтэнг нэр дэвшүүлэн хувьцаа эзэмшигчдийн хурлаараа сонгож ажилласан. Одоо бидэнд цаашдын төлөвлөгөөний чиглэлийн хүрээнд ТУЗ-ийн хараат болон ердийн гишүүнд нэр дэвшигчдийг нэр дэвшүүлсэн байгаа.

Хувьцаа эзэмшигч Д.Энхтуяа: Тарааж өгсөн материалаас нэр дэвшигчдийн анкеттай танилцсан байгаа тул дэлгэрэнгүй танилцуулга шаардлагагүй нэр дэвшигчид өөрсдийгөө товч танилцуулна уу.

Нэр дэвшигчид өөрсдийгөө товч танилцуулав.

1. Батчулууны Анхболд: Булигаар ХК-ийн гүйцэтгэх захирал, 2019 оны 7 дугаар сараас хойш компанийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байгаа.
2. Батчулууны Баянжаргал: Дархан минж ХХК-ийн гүйцэтгэх захирал, 2019 оны 7 дугаар сараас хойш компанийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байгаа.
3. Анхболдын Энхмэнд: Лугати ХХК-ийн гүйцэтгэх захирал, 2019 оны 7 дугаар сараас хойш компанийн ТУЗ-ийн даргаар сонгогдон ажиллаж байгаа.
4. Довжидын Гансүх: Булигаар ХК-ийн үйлдвэрлэл хариуцсан захирал, 2019 оны 7 дугаар сараас хойш компанийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байгаа.
5. Бямбабаярын Баттүшиг: Булигаар ХК-ийн технологич арьс, шир боловсруулах салбарт олон жил тасралтгүй ажилласан ажилласан туршлагатай. Энэ жил шинээр ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшиж байгаа.
6. Цэрэндагвын Мөнхлхагва: Булигаар ХК-ийн хүний нөөцийн ахлах менежер, барилга, уул уурхайн салбарт мэргэжлээрээ олон жил ажилласан туршлагатай. 2022 оноос Булигаар ХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байгаа.
7. Жадамбын Эрдэнэбат: МУИС-ийг математикч мэргэжлээр төгссөн. Үнэт цаас, брокерийн салбарт олон жил ажилласан туршлагатай. 2022 оноос Булигаар ХК-д хараат бус гишүүнээр сонгогдон ажиллаж байгаа.
8. Төмөрбаатарын Болд: Украин улсын Машин байгууламжийн дээд сургуулийг инженер мэргэжлээр төгссөн. Үнэт цаас, брокерийн салбарт олон жил ажилласан туршлагатай. 2022 оноос Булигаар ХК-д хараат бус гишүүнээр сонгогдон ажиллаж байгаа.
9. Чулуунбаатарын Нямдорж: Нягтлан бодогч, эдийн засагч эрх зүйч мэргэжлээр төгссөн. Санхүүгийн болон татвар, аудитын чиглэлээр төрийн болон хувийн хэвшлийн компанид олон жил ажилласан туршлагатай. 2022 оноос Булигаар ХК-д хараат бус гишүүнээр сонгогдон ажиллаж байгаа.

САНАЛ ХУРААЛТ:

Санал өгөх санамжийг танилцуулан санал хураалтыг эхлүүлсэн бөгөөд санал хураалт 5 минут үргэлжлэв. 5 минут түр завсарлав. Тооллогын комисс саналыг хураалтын дүнг нэгтгэв.

САНАЛ ХУРААЛТЫН ДҮНГ ТАНИЛЦУУЛАХ:

Тооллогын комиссын дарга: Хувьцаа эзэмшигчдийн хурлын санал асуулгын тооллогын дүнг танилцуулахад бэлэн боллоо. Тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулъя.

Санал хураалтын дүнгийн тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.8 дахь заалт, Булигаар ХК-ийн 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн асуудлуудаар санал өгсөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн санал хураалтын дүнг нэгтгэн тоолсныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

- Нэг. Санал хураалтаар 88.16 хувийн саналын эрхтэй 352,815,764 ширхэг хувьцааны 11 ширхэг саналын хуудас хураасныг тооцсугай.
- Хоёр. Компанийн байранд 39.14 хувийн саналын эрхтэй 156,630,000 ширхэг хувьцааны 1 ширхэг саналын хуудас ирүүлснийг дурдсугай.

Гурав. Компанийн 2022 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хувьцаа эзэмшигчдийн саналын эрхийн олонхоор буюу 100% хувийн саналаар баталсныг мэдэгдсүгэй.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн саналын тоо					
Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
352,815,764	100%	0	0%	0	0%

Дөрөв. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн цалин урамшуулал, зардлын төсөв батлах тухай хэлэлцэх асуудлыг хувьцаа эзэмшигчдийн саналын эрхийн олонхоор буюу 100% хувийн саналаар баталсныг мэдэгдсүгэй.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн саналын тоо					
Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
352,815,764	100%	0	0%	0	0%

Тав. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай асуудлыг кумулятив аргаар 352,815,764 ширхэг хувьцаатай 11 хувьцаа эзэмшигч саналаар дараах нэр дэвшигчид нь Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдэд сонгогдсоныг мэдэгдсүгэй.

Ердийн гишүүдэд:

№	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчийн нэр	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	Батчулууны Анхболд	88.1%	352,815,664
2	Анхболдын Энхмэнд	88.1%	352,815,664
3	Батчулууны Баянжаргал	88.1%	352,815,664
4	Довжидын Гансүх	88.1%	352,815,664
5	Бямбабаярын Баттүшиг	88.1%	352,815,664
6	Цэрэндагвын Мөнхлхагва	88.1%	352,815,664

Хараат бус гишүүдэд:

№	ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчийн нэр	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	Жадамбын Эрдэнэбат	88.1%	252,816,114
2	Төмөрбаатарын Болд	88.1%	252,816,114
3	Чулуунбаатарын Нямдорж	88.1%	352,815,664

Тооллогын комиссын дарга Ю.Дүгэрмаа

Тооллогын комиссын гишүүд Д.Энхзул, Б.Саруул

ХУРЛААС ГАРАХ ТОГТООЛЫГ ТАНИЛЦУУЛАХ:

ТУЗ-ийн нарийн бичиг Н.Ууганцэцэг танилцуулав.

**Компанийн 2022 оны жилийн үйл ажиллагаа
болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн
дүгнэлтийг батлах тухай**

МУ-ын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, Булигаар ХК-ийн 2022 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн үйл ажиллагаанд өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн

дээр 2023 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

Нэг. “Булигаар” Хувьцаат компанийн 2022 оны жилийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг Нэгдүгээр хавсралт ёсоор баталсугай.

ХУРЛЫН ДАРГА Б.АНХБОЛД

**Төлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүдийг сонгох тухай**

МУ-ын Компанийн тухай хуулийн 62 дүгээр зүйлийн 62.1.7 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.1, 77.4 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны 23/01НДХ дүгээр тогтоол, Булигаар ХК-ийн 2023 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

Нэг. “Булигаар” Хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дараах бүрэлдэхүүнтэйгээр сонгосугай.

Төлөөлөн Удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр:

Батчулууны Анхболд

Анхболдын Энхмэнд

Батчулууны Баянжаргал

Довжидын Гансүх

Бямбабаярын Баттүшиг

Цэрэндагвын Мөнхлхагва

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдээр:

Жадамбын Эрдэнэбат

Төмөрбаатарын Болд

Чулуунбаатарын Нямдорж

Хоёр. Компанийн үйл ажиллагааг үр ашигтай удирдан зохион байгуулж, холбогдох хууль, дүрэм журмын дагуу ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА Б.АНХБОЛД

**Төлөөлөн удирдах зөвлөлийн
2023 оны зардлын төсөв батлах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дүгээр зүйлийн 62.1.13 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны 23/01 ЦУХ тоот тогтоол, Булигаар ХК-ийн 2023 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

Нэг. Булигаар ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны зардлын төсвийг Нэгдүгээр хавсралтад зааснаар баталсугай.

Хоёр. Баталсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж, цалин хөлс, урамшууллыг үр дүн харгалзаж олгож байхыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА Б.АНХБОЛД

Хурлын дарга Б.Анхболд: Булигаар ХК-ийн 2023 оны 4-р сарын 21-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал үүгээр өндөрлөж байна. Хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа

Хурал 15 цаг 55 минутад өндөрлөв.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ:



Б.АНХБОЛД

Хурлын тэмдэглэл хөтөлсөн.

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧИГ: *Н. Ууганцэцэг*

Н.УУГАНЦЭЦЭГ